

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ ТАЙЛАН

2019.12.13

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн зөвлөл нь байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны төлөвлөгөөг 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.

2. *Сургалт*: Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Дотоод хяналт шалгалт, мониторингийн хэлтэстэй хамтарсан сургалтыг тус газрын чиглэл, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдэд болон Төв лаборатори дээр 2019 оны 5 дугаар сард зохион байгуулсан. Уг сургалтыг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, албан хаагчдын эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албан зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 36/32 дугаартай тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” зэрэг сэдвүүдээр зохион байгуулж, нийт 296 албан хаагчид хамрагдсан байна.

Тус газрын улсын /ахлах/ байцаагч, албан хаагчдыг ёс зүй, сахилга хариуцлагатай ажиллах, авлигаас ангид байж, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх талаар 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 5 чиглэлийн болон 6 дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдэд сургалт зохион байгуулж, нийт 192 улсын /ахлах/ байцаагч, албан хаагчид хамрагдав. Мөн НМХГ-ын нийт албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Мэдээллийн цаг”-аар “Шинэ үеийн төрийн алба”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ёс зүй, ашиг сонирхолын зөрчил” сэдвүүдээр сургалт зохион байгуулж нийт 334 албан хаагчдыг хамруулав.

3. *Сурталчилгаа*: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албан зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 36/32 дугаартай тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам” болон тус газрын Ёс зүйн зөвлөлийн 2019 оны хагас жил, жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг НМХГ-ын цахим хуудсанд шинэчлэн байршуулсан. Мөн “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг тус газрын чиглэл болон дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүд, Тамгын газар, Төв лабораторийн нийт албан хаагчдад албан бичгээр хүргүүлэн танилцуулав.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу тус газрын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/13 дугаартай тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулсан. 2019 оны жилийн эцсийн байдлаар Ёс зүйн зөвлөлд 26 улсын /ахлах/ байцаагчийн ёс зүйтэй холбогдох 17 гомдол ирснийг 4 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн. Ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон 16 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай 6 тогтоол гарсан ба 7 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй, Ёс зүйн зөвлөлийн хэлэлцэх асуудалд хамаарахгүй 2 гомдол байна. /хүснэгт 1/.

№	Гомдол гаргасан, иргэн аж ахуйн нэгжийн нэр	Зөрчил гаргасан улсын /ахлах/ байцаагчийн нэр	Гомдлын агуулга	Шийдвэрлэсэн байдал
1	Астра вилла СӨХ-ны гүйцэтгэх захирал Д.Ганбаатар	ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Д.Дуламрагчаагийн ёс зүйтэй холбоотой асуудал	Орон сууны хороолол доторх зам нь эвдэрсэн тухай гомдол гаргасан. улсын байцаагч чиг үүргийнхээ хүрээнд шаардлага тавьж ажилласан уу гэвэл эхлээд ажилласан... Гэтэл зөрчил арилахгүй байна. Нөхцөл байдал нь улам дордсон... Урьд өмнө нь өгч байсан албан шаардлагаа хуулбарлан дахиж албан шаардлага өгсөн гээд надад өгсөн. Энэ бол ёс зүйтэй холбоотой асуудал гэж ойлгож байгаа...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар улсын ахлах байцаагч Д.Дуламрагчаагийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
2	ЧД-ийн 2-р хорооны иргэн Ш.Эрдэнэчимэг	Дэд дарга С.Даваасүрэн, ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Д.Дэлгэрмаа нарын ёс зүйтэй холбоотой асуудал	Дээд айлаас ус алдсан... шугам сүлжээг шалгаж, зөрчлийн хэрэг нээж өгнө үү... Д.Дэлгэрмаа байцаагч Монос групп-тэй хуйвалдсан байж магадгүй гэж би бодож байгаа...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар улсын ахлах байцаагч Д.Дэлгэрмаагийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
3	ХУД-ийн 15-р хорооны иргэн Ч.Гүнжидмаа	БГД дэх МХХ-ийн Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Г.Батнасан, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Болормаа нарын ёс зүйтэй холбоотой асуудал	Улсын байцаагч ажилтан чинь илтэд хувийн ашиг сонирхлоор хандсан. Жоохон хүүхэд эрүүл мэндээр хохирчоод байхад арга хэмжээ авахгүй “500000 төгрөгөөр торголоо. Болоо юм биш үү” гэж хэлсэн...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар улсын ахлах байцаагч Г.Батнасан, улсын байцаагч Б.Болормаа нарын ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
4	ХУД дэх МХХ-ийн 1-р хорооны иргэн Б.Оюунтуяа	ХУД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Н.Энхмаагийн ёс зүйтэй холбоотой асуудал	Иргэний гаргасан гомдлыг шалгаж байхдаа уцаарласан гэх ...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар улсын байцаагч Н.Энхмаагийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.

5	American school of UB, Ерөнхий захирал Д.Оюунсүрэн	ЭМБСХХ-ийн Боловсролын хяналтын улсын байцаагч Х.Цогоогийн ёс зүйтэй холбоотой асуудал	Ажилтай завгүй байхад өдөр болгон утсаар дарамталж ирж мэдүүлэг өг гэж 4-5 удаа зовоосон...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар улсын байцаагч Х.Цогоогийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
6	Иргэн Ч.Оюунтуяа /5-р хороо/	БНД дэх МХХ-ийн дарга С.Баясгалангийн ёс зүйтэй холбоотой асуудал	Тус хэлтэст ажилладаг миний охиныг хамт олны дунд загнаж, доромжилсон....	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар БНД дэх МХХ-ийн дарга С.Баясгалангийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, С.Баясгалан даргад МУ-ын ЗГ-ын 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.7.ё дахь заалтыг зөрчсөн байх тул 4.2.1 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага /уучлал гуйх/ хүлээлгэх тухай тогтоол, тус хэлтсийн улсын байцаагч Б.Хуланд уг дүрмийн 3.1.7.и, 3.1.5.а дахь заалтуудыг зөрчсөн байх тул 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ тус тус гаргасан.
7	Дотоод хяналт шалгалт, мониторингийн хэлтсээс	Улсын байцаагчдын ёс зүйтэй холбоотой асуудал	Улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалт хийдэг аж ахуйн нэгж байгууллагуудад ном, хоолны технологийн CD, соронзон наалтыг зарсан гэх...	2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, уг асуудалд холбогдсон 10 улсын /ахлах/ байцаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.2.а, 3.1.4.б дахь заалтуудыг зөрчсөн байх тул 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
8	Ниса ХХК-ны захирал, өмгөөлөгч К.Султанбек	АЧХХ-ийн ЭХХ-ын улсын байцаагч Б.Түшигбатын ёс зүйтэй холбоотой асуудал	... хамгийн өндөр торгуулиар торгосон, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно гэж заналхийлсэн гэх ...	2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар улсын ахлах байцаагч Б.Түшигбатын ёс зүйтэй

				холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
9	ХУД дэх МХХ-ийн 1-р хорооны иргэн Б.Оюунтуяа	ХУД дэх МХХ-ийн Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Баянхутагийн ёс зүйтэй холбоотой асуудал	Иргэний гаргасан гомдлыг шалгаж байхдаа уцаарласан, гомдол гаргагчийг торгоно гэж сүрдүүлсэн гэх ...	2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар улсын ахлах байцаагч Б.Баянхутагийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
10	“Алтан тариа” ХХК-ны итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Мягмаржав	СХД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Д.Бат-Очирын ёс зүйтэй холбоотой асуудал	Хорио цээрийн дэглэм тогтоосон захирамжийг урьдчилан мэдэгдээгүй, хяналт шалгалтын үед өөрөө байгаагүй боловч тээврийн хэрэгслийн баримт бичиг, жолооны үнэмлэхийг хураан авч 5 хоногийн турш, жолоочийг ажилд гарах боломжгүй болгосон, бичиг баримтаа авах гэж олон удаа явуулсан, ард иргэдэд хүндэтгэлтэй хандаагүй гэх ...	2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.4.а, дахь заалтыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
11	Иргэн Х.Мөнхтуяа /ДХШМХ/	Дэд дарга Б.Батшагайн албан бичигт нэмэлт тайлбар тодруулга авах тухай асуудал	2018 оны 0202/4871 тоот албан бичигт нэмэлт тайлбар тодруулга авах...	Ёс зүйн зөвлөлийн хэлэлцэх асуудал биш тул буцаав. /ДХШМХ/
12	ЭИХХЦХХ-ийн дарга Н.Гэрэлт-Од	ЭИХХЦХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Ч.Отгонтөрийн ёс зүйтэй холбоотой асуудал	Хэлстийн дарга, ахлах нарыг хяналт шалгалтаар очих үед өөрийн хяналтад байсан бараа бүтээгдэхүүнийг цайны газар руу зөөсөн гэх	Дахин шалгуулж, нэмэлт тайлбар, нотлох баримт авахаар ДХШМХ-т буцаав.
13	СБД-ийн 3-р хорооны иргэн Я.Ариунаа	БГД дэх МХХ-ийн Эмчилгээний чанарын улсын ахлах байцаагч Г.Батнасангийн ёс зүйтэй холбоотой асуудал	Утсаар ярихдаа дээрэнгүй өнгө аястай ярьсан, төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэг чадварт үл нийцэж, өргөсөн тангарагтаа үнэнч шударгаар ажиллах чадахгүй байх тул арга хэмжээ авч өгнө үү гэх	2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.а дахь заалтыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.

14	ДХШМХ-ээс	ЭИХХЦХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Ч.Отгонтөрийн ёс зүйтэй холбоотой асуудал	Хяналт шалгалтыг дахин хийсэн болон нэмэлт тайлбар, мэдүүлэг авсан тухай	2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 4 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.2.а, 3.1.4.б дахь заалтуудыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
15	СБД-ийн иргэн Р.Батсүрэн	ЭИХХЦХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Д.Должинсүрэнгийн ёс зүйтэй холбоотой асуудал	Улсын байцаагчид арга хэмжээ авахуулах тухай	Ёс зүйн зөвлөлийн хэлэлцэх асуудал биш албан бичгээр хариу өгөв.
16	БЗД дэх МХХ-ийн Боловсролын хяналтын улсын байцаагч Д.Одончимэг	БЗД дэх МХХ-ийн Боловсролын хяналтын улсын байцаагч Д.Одончимэг улсын байцаагчийн үнэмлэх тэмдгээ үрэгдүүлсэн тухай	Улсын байцаагчийн үнэмлэхээ хулгайд алдсан гэх	2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.а дахь заалтыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
17	Ч.Энхсаран нарын 20 багш, ажилтнаас	СБД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгаалын хяналтын улсын байцаагч Ц.Отгонборын ёс зүйтэй холбоотой асуудал	СБД-ийн 1-р сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд шалгалт хийхдээ ёс зүйн зөрчил гаргасан гэх	2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.4.б дахь заалтыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.

18	“Хан-Уул Агро” ОНӨААТНГ-ын захирал Ц.Цогтсайхан	ХУД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Л.Мөнхсаруулын ёс зүйтэй холбоотой асуудал	Өндөржүүлсэн бэлэн байдлын үед штабд ажиллах хуваарийг нь хэлж сануулахад уурлаж, эгдүүцсэн гэх	2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, улсын байцаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”- ийн 3.1.1.а, 3.1.4.б дэх заалтыг зөрчсөн байх тус дүрмийн 4.2.2 дахь заалтын дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
----	--	---	---	---

4. Архив, албан хэрэг хөтлөлт:

Ёс зүйн хорооны 2018 оны хурлын тэмдэглэл, дүгнэлт, үйл ажиллагаатай холбогдолтой тайланг архивын нэгж болгон хавтаслан архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

5. Судалж буй өргөдөл гомдол:

байхгүй.

ХЯНАСАН:
ХЭЗХ-ИЙН ДАРГА

О.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗХ-ИЙН ЭРХ ЗҮЙН
МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЙГАЛМАА